

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.05.07-05.11

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцааны ханш өсөн, энэ оны хамгийн дээд өсөлтийг үзүүллээ.

Долоо хоногийн сүүлээр FactSet компанийн мэдээлснээр S&P 500 индекст багтдаг компаниудын 1-р улирлын орлогын үзүүлэлт өмнөх оны мөн үеэс 24.9%-аар нэмэгджээ. Тус компанийн судалгаагаар 5 компани тутмын 4-ийнх нь орлогын үзүүлэлт урьдчилан таамаглаж байснаас өндөр үзүүлэлттэй байв.

Дотоодын газрын тосны үнэ нэмэгдэж эрчим хүчний салбарын компаниудын хувьцааны ханш өссөн байна. Түүнчлэн, Иран улсын газрын тос нийлүүлэх явцад саатал гарч, Саудын Арабын эрх баригчид олон улсын газрын тосны үнэ 80 ам. долларт хүрнэ хэмээн мэдэгдсэн нь газрын тосны ханш өсөхөд нөлөөлжээ.

Европ: Европын компаниудын 1-р улирлын орлогын тайлангийн зэрэг үзүүлэлтүүд болон газрын тосны ханшийн өсөлт Европын индексүүдийг өмнөх долоо хоногоос өндөр үзүүлэлттэй хаагдахад нөлөөлөв. Зах зээл дээр бага хэмжээний арилжаа явагдаж, ханш хэлбэлзэл үүсээгүй байна.

Европын дийлэнх компаниудын 1-р улирлын тайлан таамаглаж байснаас өндөр байлаа.

Фүнтийн ханш суларснаар үндэстэн дамнасан компаниудын борлуулалтын орлого нэмэгдэж, FTSE 100 индексийг өсгөв.

Английн төв банк 2-р улирлын инфляцийн түвшингийн урьдчилсан таамгаа 2.7%-аас 2.4% болгон бууруулсан бол ДНБ-ий өсөлтийг 1.4%-аас 1.8% болно хэмээн тооцоолжээ.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш энэ долоо хоногт өсөлттэй байв.

Иений ханш харьцангуй тогтвортой байж, ам. долларын эсрэг 109.2 нэгж болон хаагдсан нь 2017 оны сүүлчээс 3%-аар чангарсан байна.

Ройтерс агентлагийн шинжээчдийн үзэж байгаагаар энэ оны 1-р улиралд экспортын барааны эрэлт, дотоодын хэрэглээ болон орон сууцны хөрөнгө оруулалт буурсантай холбоотойгоор Япон улсын эдийн засгийн өсөлт удааширчээ. Энэхүү 2015 оноос хойш анх удаа тохиож буй эдийн засгийн удааширал нь түр зуурын хэмээн шинжээчид үзэж байна.

БНХАУ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан дараагийн шатандаа орлоо. Энэ удаад БНХАУ-ын худалдааны асуудал эрхэлсэн төлөөлөгчид АНУ-ын Вашингтон хотноо айлчилж хэлэлцээр хийв. Тус хэлэлцээрийн үеэр АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп Хятад улсаас орж ирдэг тариф ногдуулж буй импортын барааны жагсаалтыг эцсийн байдлаар танилцуулжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,253.48	-3.16% ▼
Dow Jones	АНУ	24,831.17	2.34% ▲
S&P 500	АНУ	2,727.72	2.41% ▲
Nasdaq	АНУ	7,402.88	2.68% ▲
S&P/TSX	Канад	15,959.50	1.46% ▲
FTSE 100	Их Британи	7,724.55	2.08% ▲
S&P/ASX 200	Австрали	6,116.20	0.88% ▲
Nikkei 225	Япон	22,758.48	1.27% ▲
Hang Seng	Хонг Конг	31,122.06	3.99% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.00
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.19
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.82
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.84
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.20
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.59
TDBM' 2020	USD	9.3%	106.34

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үеү
Libor 1M	1.919	-0.01 ▼
Libor 3M	2.343	-0.03 ▼
Libor 6M	2.515	-0.01 ▼
Libor 1YR	2.766	-0.01 ▼
US 6M Bond	2.027	0.00 ▲
US 2YR Bond	2.535	0.04 ▲
US 3YR Bond	2.685	0.06 ▲
US 5YR Bond	2.830	0.05 ▲
US 10YR Bond	2.960	0.01 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.05.11	Өөрчлөлт
USD	2,401.46	-0.05% ▼
CNY	378.56	0.12% ▲
EUR	2,860.14	-0.53% ▼
RUB	38.90	2.31% ▲
KRW	2.25	0.90% ▲
JPY	21.97	-0.27% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,321.85	0.56% ▲
Мөнгө /spot/	16.72	1.15% ▲
Зэс	311.85	1.07% ▲
Нүүрс	99.75	2.20% ▲
WTI газрын тос	70.69	1.39% ▲
Brent газрын тос	77.1	2.98% ▲
Байгалийн хий	2.82	4.06% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018.III	6.60%
Бодлогын хүү	2018.III	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.III	10.07%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.III	12.80%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.III	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.III	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.III	11.30%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 53 компанийн 672.7 сая төгрөгийн 5,675,874 ширхэг хувьцаа арилжигдав.

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” /JLT/ компанийн хувьцаа 31.46%-аар буюу хамгийн ихээр өсч 211 төгрөгт хүрч хаагдсан бол “Увс чацаргана” /CHR/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 935 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр 2 удаагийн хэлцлээр нийт 429 ширхэг үнэт цаас 42.9 сая төгрөгөөр арилжаалагджээ.

Компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр арилжаа явагдаагүй байна.

5-р сарын 11-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,385 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,253.48 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.16%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногоор/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	715.6
Зах зээлийн үнэлгээ	2,385,014.1

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,253.48	-3.16% ▼
MSE I индекс	9,240.81	-5.18% ▼
MSE II индекс	9,818.81	-0.89% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛендМН ББСБ	5,006,211	236,283,115
АПУ	300,574	184,142,097
Говь	3,119	67,416,580
Таван Толгой	5,891	57,998,120
Багануур	19,172	36,875,369

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	211.00	31.46% ▲
Мон-Ит Булигаар	10,900.00	14.14% ▲
Евроазиa капитал холдинг	1,150.00	13.86% ▲
Монгол нэхмэл	3,345.00	11.35% ▲
Авто зам	4,500.00	9.76% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Увс чацаргана	935.00	-15.00% ▼
Шивээ овоо	2,050.00	-14.41% ▼
Монинжбар	150.00	-14.29% ▼
Цагаантолгой	2,400.00	-11.11% ▼
Хишиг Уул	900.00	-10.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
БиДиСек	222,449,276
Мирэ Эссет Секьюритис Монгол	200,844,693
Ти Ди Би Капитал	128,311,277
Бумбат-Алтай	112,884,827
Стандарт инвестмент	111,655,650

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	597.24	635,572
Таван толгой	9,535.00	502,163
МИК	10,510.00	217,655
Говь	21,340.00	166,476
Сүү	210.00	72,240

ЗГҮЦ-НЫ АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	427	42,700,000	100,000	100,000	156	16.993%
2	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	2	220,540	110,340	110,200	104	13.955%

КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

Компанийн бондын хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төгрөг/	Нийт ногдол ашиг /сая төгрөг/	Тайлант үеийн нийт цэвэр ашиг /сая төгрөг/	Цэвэр ашигт эзлэх хувь /%/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой ХК	2,410.00	126,923.13	141,054.64	90.0%	2018.04.16	2018.04.03	2018.04.27-с
2	EER	Ариг гал ХК	21.33	74.21	148.46	50.0%	2018.04.25	2018.04.02	2018 оны 9-р сараас
3	BDL	Могойн гол ХК	100.00	82.96	245.55	33.8%	2018.04.26	2018.01.18	-
4	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	56.60	7.66	2,329.13	0.3%	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
5	TAL	Талын гал ХК	50.00	34.71	143.25	24.2%	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
6	AND	Анд-Энерги ХК	1.27	99.15	121,400.00	0.1%	2018.02.24	2018.03.16	-
7	SUL	Жуулчин дүти фрий ХК	10,000.00	653.62	1,070.68	61.0%	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
8	GTL	Гутал ХК	1,270.00	83.01	2,492.84	3.3%	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
9	BNG	Баянгол зочид буудал ХК	355.00	150.19	2,481.23	6.1%	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
10	APU	АПУ ХК	10.00	10,641.82	24,871.94	42.8%	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
11	BTG	Баянтээг ХК	100.00	25.26	1,131.61	2.2%	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
12	MIE	Материалимпекс ХК	10.00	13.68	492.98	2.8%	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
13	HRD	Хүрд ХК	497.00	67.23	694.41	9.7%	2018.02.15	2018.02.23	2018 .06.30-ны дотор
14	SUU	Сүү ХК	3.00	1,032.00	2,430.13	42.5%	2018.02.14	2018.04.05	2018.05.21-с
15	MNP	Монгол шуудан ХК	3.68	366.48	911.83	40.2%	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
16	MMX	Махимпекс ХК	100.00	380.07	354.75	107.1%	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
17	TCK	Талх чихэр ХК	170.00	174.03	1,128.02	15.4%	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
18	GHC	Ган Хийц	100.00	24.25	-158.94	-	2018.02.09	-	-
19	ADL	Адуун чулуун ХК	130.00	409.67	435.50	94.1%	2018.02.07	2018.03.01	-
20	TAH	Тахь-ко ХК	108.00	128.52	790.06	16.3%	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
21	UBH	Улаанбаатар хивс ХК	100.00	40.48	247.12	16.4%	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
22	GOV	Говь ХК	220.00	1,716.25	17,474.71	9.8%	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
23	HRM	Гермес центр ХК	5.00	392.72	715.41	54.9%	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монгол базальт” ХК: Анхдагч зах зээлийн захиалга 5-р сарын 14-23-ны хооронд явагдана

“Монгол Базальт” нээлттэй хувьцаат компани болж нийт хувьцааны 30 хувийг тус бүр нь 380 төгрөгийн тогтоосон үнээр олон нийтэд санал болгохоор боллоо. Олон нийтэд 380 төгрөгөөр санал болгож байгаа ч бизнес үнэлгээгээр нэгж хувьцаа нь 639 төгрөг байсан байна. Ингэснээр хувьцаа Базальт чулуу олборлож, “Basaltwool” брэндийн дулаан, дуу чимээ тусгаарлах зориулалттай чулуун хөвөн үйлдвэрлэгч компани дотоодын хөрөнгийн зах зээлээс 6.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр болж байна. Үүнээс 50 хувь буюу 3.2 тэрбум төгрөгийг стратегийн хөрөнгө оруулагчдаас татах юм. Хэдий тийм боловч нийтэд санал болгон худалдаалах хувьцааг зах зээлд 100 хувь арилжаалсан тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцно гэж Санхүүгийн зохицуулах хороо мэдээллээ. Анхдагч зах зээлийн захиалга энэ сарын 14-23-ны өдрүүдэд явагдана. Татан төвлөрүүлсэн 6.4 тэрбум төгрөгөөр тус компани 2018-2020 онд чулуун хөвөн үйлдвэрлэлийг боловсронгуй болгож, цаашид бүтээгдэхүүнээ экспортлохоор төлөвлөж байгаа юм байна. “Монгол Базальт” компани сүүлийн жил гаруйн хугацаанд IPO гаргахаар бэлджээ. эзэмшигчдэдээ нэгж хувьцаагаа бодит үнэ цэнээс 40.5 хувиар хямд санал болгож байгаа гэж тус компанийн захирал мэдээллээ.

“Монгол Базальт” компанийн захирал Л.Ариунболдын мэдээлснээр бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд компанид техник, технологийн шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байгаа ажээ. Тиймээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн 39.3 хувийг чулуун хөвөнгийн үйлдвэрийн өргөтгөлд зарцуулахаар төлөвлөсөн байна. Ингэснээр бүтээгдэхүүний чанар сайжирч, өртөг буурч, үйлдвэрийн хүчин чадал 5-8 мянган тонноор нэмэгдэнэ гэж тооцоолжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн арилжааг түр зогсоолоо

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэгж хувьцааг 100 хувааж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 5 дугаар сарын 07-ны өдрийн 34 тоот албан шаардлагаар “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хувьцааны арилжааг хувьцааны байршуулалт “ҮЦТХТ”-д хийгдэх хүртэлх хугацаанд түр зогсоолоо.

Эх сурвалж: MSE.mn

Жэнко тур бюро ХК: Энэ онд “Чингисийн хөшөө” болон “XIII зуун” цогцолборт засвар шинэчлэл хийнэ

Энэ оны хурлын шийдвэрүүдээс харвал “Жэнко тур бюро” компани энэ онд “Trip Addeka”, “Fram Travel” зэрэг зургаан компанитай хэлэлцээ хийж хамтран ажиллахаар тохиролцсон байна. Ингэснээр Францаас 100 жуулчин хүлээн авахаар урьдчилсан байдлаар захиалга хүлээн авчээ. 2017 онд “Чингисийн хөшөө” цогцолборын борлуулалтын орлого төлөвлөгөөнөөс 119 хувиар давж биелсэн ч “XIII зуун” цогцолборын борлуулалтын орлого 80.7 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. 2018 онд “Чингисийн морьт хөшөө” болон “XIII зуун” цогцолборт засвар шинэчлэл хийхээр төлөвлөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Erdene Resource Development” компани “Алтан нар” төслийнхөө нөөцийг шинэчлэн тогтоолоо

Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Erdene Resource Development” компани “Алтан нар” төслийнхөө нөөцийг шинэчлэн тогтоосон байна. Шинэчилсэн тооцоогоор таван сая тоннын таамаг, 3.4 сая тонн боломжит эрдсийн нөөцтэй гэж тогтоожээ.

Өмнө нь 2015 онд энэхүү талбайн нөөцийг урьдчилан тогтоож байсан бөгөөд үүнтэй харьцуулахад талбайн алтны эрдэсжилтийн таамаг нөөц 208 хувиар, боломжит нөөц 172 хувиар нэмэгдсэн байна. Ялангуяа алтны таамаг нөөц нь 452.9 мянган унц буюу тонн хөрс тутамд 2.8 грамм алт байгаа бол боломжит нөөц нь 277.1 мянган унц гэж үзсэн байна. Төслийнхөө нөөцийг шинэчлэн тогтоосны дараа “Erdene Resource Development”-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал Питер Акерлей “Бид энэ үр дүнд сэтгэл хангалуун байна. Энэ талбайгаас зүүн өмнө зүгт 16 километрийн зайтай байрлах “Баян хөндий” төслийн талбайд өрөмдлөгөө үргэлжлүүлж байгаа” гэдгийг онцоллоо.

Тус компанийн хувьцааны ханш Торонтогийн Хөрөнгийн биржид пүрэв гарагийн арилжаагаар 10.53 хувиар буурч, 0.34 канад доллар болоод байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Aspire Mining” нүүрсний туршилтын тээврээ эхлүүлэхээр төлөвлөж байна

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Aspire Mining” компани Хөвсгөл аймгийн нутагт байрлах “Нүүрстэй” төсөлдөө ихээхэн анхаарч байна.

Энэ ордын талбай дээр 2018 онд 54 өрөмдлөг хийх төлөвлөгөөгөө Ашигт малтмал, газрын тосны газраар батлуулсан бөгөөд ойрын хугацаанд ажлаа эхлэхээр төлөвлөж байгаагаа мэдээллээ. Мөн “Нүүрстэй” төсөлтэй ойролцоо байрлах ордоос 100 мянган тонн нүүрс худалдаж авахаар Төрийн өмчит “PSST” ХХК-тай гэрээ байгуулжээ. Энэхүү нүүрсийг одоо байгаа төмөр замаар тээвэрлэн БНХАУ, ОХУ, БНСУ, Японы зах зээлд экспортолж, “Нүүрстэй” төслийн ТЭЗҮ-д ашиглах зорилгоор тээвэр логистик, өртөг зардлыг нь тооцох төлөвлөгөөтэй байгаа аж. “Aspire Mining” компани “Нүүрстэй” төслөөс гадна “Эрдэнэт-Овоот” чиглэлийн 547 км урт төмөр зам барихаар зорьж байна. Төмөр замын барилгын ажлын хүрээнд “China Gezhouba Group”-тай хамтран ажиллахаар болжээ.

Ерөнхий сайд У.Хүрэлсүх дөрөвдүгээр сард БНХАУ-д айлчлах үеэр “China Gezhouba Group” энэхүү төмөр замын төслийн хүчин чадлыг баталгаажуулах хүртэл хөрөнгө оруулалттай холбоотой шийдвэр гаргах хугацаагаа сунгахаар болсон юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Entree Resources”-ийн I улирлын алдагдал жилийн өмнөхөөс 46 хувиар буурчээ

Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Entree Resources” компанийн алдагдал I улиралд 0.7 сая ам.доллар болж, жилийн өмнөхөөс 46 хувиар буурсан байна. Тус компанийн үйл ажиллагааны мөнгөн урсгал 0.2 сая ам.доллар болжээ.

Мөн гуравдугаар сарын эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь 6.6 сая ам.доллар болсон талаар санхүүгийн тайландаа дурджээ. “Оюу Толгой” ХХК-тай байгуулсан хамтарсан хөрөнгө оруулалттай компани дахь оролцоогоороо дамжуулан “Entree Resources” компани “Оюу Толгой” төслийн “Heruga”, “Hugo North” хэсгийн 20 болон 30 хувийг эзэмшиж байна. Тиймээс тус компанийн хувьд “Оюу Толгой” төслийн бүтээн байгуулалтын ажил чухал ач холбогдолтой юм. “Entree Resources” компани Монгол дахь менежмент, маркетинг зэрэг үйл ажиллагааны зардлаа 2018 онд 1.2-1.5 сая ам.доллар байлгахгаар тооцож байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Xanadu Mines: “Зараа” талбайн нөөцийн хэмжээг тооцоолох ажил үргэлжилж байна

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Xanadu Mines” компани “Зараа” талбайн шинэчилсэн мэдээллийг танилцууллаа. “Зараа” талбайд сүүлд хийгдсэн өрөмдлөгөөр эрдэсжилт бүхий судал илрүүлснийг тус компанийн Гүйцэтгэх захирал Анджо Стюарт мэдэгдсэн юм.

Энэ нь “Хармагтай” ордын нөөц боломж цаашид ч нэмэгдэх боломжтойг илтгэсэн үр дүн болсныг тэрбээр онцолжээ. “Xanadu Mines” компани өрөмдлөгийн дүнд 458 метрийн гүнд 0.3 хувийн агууламжтай зэс, тонн тутамд 0.27 грамм алтны агууламж илрүүлсэн бөгөөд 825 метрийн гүнд 0.5 хувийн агууламжтай зэс, тонн тутамд 0.45 грамм алтны агууламж илрүүлжээ. “Зараа” талбайн нөөцийн хэмжээг тооцоолох ажил үргэлжилж байгаа аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

ЗГ: Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-д аудит хийж байна

Дорноговь аймагт барихаар төлөвлөж байгаа газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-д аудит хийх ажил үргэлжилж байна. Урьдчилсан тооцоогоор Энэтхэгийн нэг тэрбум ам.доллараар баригдах боловсруулах үйлдвэр жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулна.

Ингэснээр “Евро 4”, “Евро 5” стандартын шаардлага хангасан 560 мянган тонн автобензин, 670 мянган тонн дизель түлш, 107 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэнэ гэж тооцож байгаа ажээ. Хэдий тийм боловч нарийвчилсан ТЭЗҮ-ээр энэ тоонд өөрчлөх орох хүлээлттэй байна.

Түүхий эдээ Дорнодын XIX, XXI талбайгаас татах боломжтой дэд бүтэцтэй ойрхон гэх шалтгаанаар Алтанширээг сонгосон аж. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар газрын тос боловсруулах үйлдвэр барих ажлыг энэ оны III улиралд багтаан эхлүүлж, 2022 онд хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа талаар мэдээлж байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ОУВС: 2018 онд Монгол Улсын төсвийн орлого ДНБ-ий 27 хувьд хүрэх төлөвтэй

Олон Улсын Валютын Сангийн тооцоолсноор 2018 онд Монгол Улсын төсвийн орлого дотоодын нийт бүтээгдэхүүний 27 хувьд хүрэх төлөвтэй байна. Энэ нь 2017 оны төсөөллөөс 2.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Төсвийн орлогыг бууруулж төсөөлсөн шалтгаан нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт төдийлөн өсөхгүй байх эрсдэлтэй холбон тайлбарласан байна. 2018 оны гуравдугаар сарын гүйцэтгэлээр улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 50 тэрбум төгрөгөөр давж биелээд байна. Харин улсын төсвийн зардал 188 тэрбум төгрөгөөр бага гарчээ. Үндэсний статистикийн хорооны мэдээлж байгаагаар төсвийн орлого давж биелэхэд татварын орлого нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” хэрэгжиж эхэлснээс хойш 152.8 сая ам.долларын санхүүжилтийг гурван шатлалтай авсан юм. Харин донор улс, байгууллагуудыг нэмсэн нийт санхүүжилтийн дүн 2017 оны эцэст 728 сая ам.долларт хүрчээ. Монголбанкны мэдээлснээр 2018 оны хөтөлбөрийн хүрээнд орж ирэх нийт санхүүжилтийн хэмжээ 836 сая ам.доллар болж өсөх юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

СЯ: Төсвийн орлогын 50 хувьтай тэнцэх мөнгийг энэ онд өрөнд төлж байна

Сангийн яамнаас өргөн барьсан 2019 оны Төсвийн төсөөлөлд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг найман хувьд байхаар урьдчилан тооцсон байна. Харин Олон Улсын Валютын Сан 2019 онд 6.3 хувиар өснө гэж таамаглаж байгаа юм. Төсвийн хүрээний мэдэгдэлд ирэх оны Монгол Улсын төсвийн нийт орлогыг 9.7 их наяд төгрөг байхаар тооцжээ. Энэ нь 2018 оны төсвийн орлогыг 7.2 их наяд төгрөг байхаар баталж байсантай харьцуулахад өндөр дүн буюу өөдрөг төсөөлөл болж байгаа аж. Харин Олон Улсын Валютын Сангийн гурав дахь шатны үнэлгээний баг болон Захирлуудын зөвлөлийн шийдвэрийн дэлгэрэнгүй тайланд дурдсанаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд ойрын хугацаанд нүүрсний экспорт төдийлөн дэмжлэг үзүүлэхгүй гэж онцолсон байна. Хилийн боомтын асуудал үүнд нөлөөлнө гэж үзжээ.

Дөрөвдүгээр сард танилцуулсан тайланд Монгол Улсын улс төрийн орчин тогтворжоогүй байгаа нь гол эрсдэл гэж тодорхойлсон байна. Улс төрийн орчин тогтворгүй бол “Өргөтгөсөн санхүүжилт хөтөлбөр”-ийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхөөс гадна донор орнуудын санхүүжилтийг хойш татах эрсдэлтэй гэж Олон Улсын Валютын Сан дүгнэжээ. Мөн Засгийн газрын өр дотоодын нийт бүтээгдэхүүний 85 хувьтай тэнцэж байгаа нь маш өндөр хувь хэмжээ болохыг онцлоод хөтөлбөрийн гүйцэтгэлд сөрөг нөлөөтэй гэж дүгнэсэн байна. Түүнчлэн гүйцэтгэлийг дэлгэрэнгүй үнэлсэн байна. Үнэлгээний тоон үзүүлэлтүүдийн дийлэнх нь зорилтдоо хүрсэн гэж үзжээ.

Харин бүтцийн жишиг зорилтууд харьцангуй холимог үр дүнтэй байгааг онцолсон байна. Сүүлийн үнэлгээгээр бүтцийн шинж чанартай 10 зорилтын тавыг нь амжилттай биелүүлж, гурав нь УИХ-ын хаврын чуулганаар шийдэгдэх хүлээлттэй байгааг онцоллоо. Эдгээр гурван бүтцийн өөрчлөлтөд Татварын ерөнхий хуулийн багц шинэчлэл, банкний дахин хөрөнгөжүүлэх тухай хуулийн төсөл зэрэг багтаж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.